

МОНГОЛЫН ШОГ, ХОШИН НИЙТЛЭЛИЙН
ҮҮСЭЛ, ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛД

Н.Мөнхзориг*

"Идэр" дээд сургуулийн Монгол хэл, Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч,
сэтгүүл зүйн доктор (Ph.D.)

Түлхүүр үг: шог, хошин нийтлэлийн уламжлал, илчлэн шүүмжилсэн нийтлэл, хошин шог нийтлэл, шог, хошин нийтлэлийн сэдэв, бичлэгийн төрөл зүйл, хошин шог нийтлэлчид

Монголын шог, хошин нийтлэл баялаг уламжлалтай. Аль Манжийн дарлан мөлжлөгийн үед харгис хэрцгий баяд ноёдын бэлтгэд дугшин, шударга бус байдлыг нэвт шүүмжилж байжээ. Ялангуяа XIX зууны сүүл үеэс дарлан мөлжигч ихэс дээдэс, эрх ямбатай баяд ноёдын харгис хэрцгий, эрээ цээргүй явдлыг эрс шулуун эсэргүүцэн шүүмжилж, элэглэн шоглож, өгөөдөн түншиж, далд санаагаар хатгаж, хошигнон ёгтолсон бүтээл мэдэгдэхүйц олширчээ. Тухайлбал: Хатгины Гэндэн Мэйрэнгийн зохиосон «Хав, муур, хулгана гурвын үлгэр»-т ихэс лам нар, ноёдын хамжлага, харьяат нараа булаалдсан явдлыг үзүүлсэн бол Ордосын Данзан-ванжилын шүлэгт феодал ангийн ялзралыг хурц ширүүнээр шүүмжилжээ. Энэ үед ардын шог яруу найргийн мастер хуульч Сандаг «Үг» зохиолоороо нэрд гарч, амьтны дүрээр тухайн үеийн ард түмний тэсвэрлэшгүй

бэрх амьдрал, харгис ноёд, лам нарын хатуу хэрцгий авир, хахуульч шунахай байдлыг шоглон шүүмжилж байв. XIX зууны бичиг эрдмийн хүмүүс болох гүн сэтгэгч З. Агваанбалдан, Л. Агваанхайдав, догшин ноён хутагт Д. Равжаа, шүлэгч Хишигбат, Ашиг занги, Солиот Шагдар нарын ардын билэгтнүүд харгис хэрцгий баяд ноёд, ихэс дээдэстэй зүйл бүрээр мөчөөрхөн тэмцэж, үгийн хурцаар шүүмжилж байв.

Монголын шог, хошин нийтлэл нь ардын аман зохиол, нутаг нутгийн бэлэн цэцэн үгтэй хүмүүсийн яриа, ард олны дунд ихэд дэлгэрсэн Бадарчны үлгэр, Далан худалчийн үлгэр, уран цэцэн үгтэй «Бэлэн Сэнгээ»-нүүд, мөн адгуус амьтнаар, амьгүй юмаар төлөөлүүлж хүншүүлсэн хөөрөлдөөн, өчилөөр нийгмийн амьдралд хандаж, феодал ангийн бусармаг явдлыг шүүмжилсэн арвин их баялаг санг түшиглэж бий болсон байна. Эдгээр шог, хошин зүйлүүд нь аль ч нийгэмд бодитой оршиж байгаа дутагдлыг шүүмжилж, хатгаж байжээ. Ялангуяа шог, хошин нийтлэлийн шинжтэй, тухайн цаг үеэ шүүмжилсэн бүтээлүүд Монголд сэтгүүл зүй үүсэхээс өмнөх үеийн уран зохиолд багагүй орон зай

зээлж байсан нь ажиглагддаг. Энэ үүднээс авч үзвэл Монголын шог, хошин сэтгүүл зүй үүсч төлөвшихөд манай эртний уран зохиол, тэр дундаа «Үг» зохиолын нөлөө их юм.

Хувьсгалаас өмнөх үеийн бичгийн их хүмүүс амьтдаар төлөөлүүлэх, юмыг хүншүүлэх хэлбэрийг ашиглан зөөлрүүлсэн, далд утгаар ёгтлон шоглох, хошигнон даажигнах аргыг хэрэглэж байсан бол ардын хувьсгалын дараа зохиолч, сэтгүүлчид дээрх аргаас бүрэн татгалзаагүй ч амьдрал, нийгэмд оршиж байгаа гэм дутагдлыг ил, шууд шүүмжлэх боломжтой болжээ. Хэдий тийм боловч төлөөлүүлэх, хүншүүлэх арга 1940-өөд оныг хүртэл хэвлэлийн хуудаснаа элбэг үзэгдэж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Хүншүүлэл (англиар anthropomorphization) бол уран зохиолд өргөн хэрэглэгддэг аргын нэг юм. Судлаач Д. Галбаатар хүншүүллийг: «Амьдчиллын аргын нэг хэлбэр бөгөөд амьтан ба амьгүй юмст хүн мэт өгүүлэн үг үзэгдэл явдлын нуугдмал талыг нээх арга болно»¹ гэсэн бол Б. Мөнхбаяр: «Амьгүй зүйл болон хүн бус амьтай зүйлд хүний элдэв шинж байдал оруулж дүрслэх» арга гэж тодорхойлсон байдаг².

XIX зууны илчлэн шүүмжилсэн бүтээлийн буухиаг монголчууд бидний өөрсдийн бие даан гаргасан анхны тогтмол хэвлэл «Шинэ толь хэмээх бичиг», удаах хэвлэл «Нийслэл хүрээний сонин бичиг» гардан авсан байна.

«Шинэ толь хэмээх бичиг» улс орныхоо тусгаар тогтнол, эдийн засаг, ард түмнийхээ үндэсний ухамсрыг дээшлүүлэхэд саад болж байсан алив зүйлийг илчлэн шүүмжилж, бүх нийтийг эрдэм ном, соёл боловсролд сургах, цаашлаад улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний

эрх чөлөөг бататгахыг уриалсан идэвхтэй байр суурьтай байжээ.

«Нийслэл хүрээний сонин бичиг» нь мөн л Монгол орны гадаад, дотоод байдал, улс төрийн амьдрал, аж ахуй, соёлын асуудал, урлаг утга зохиол, ёс суртахуун, шударга бус татвар гувчуур зэрэг сэдвийг өргөн тусгадаг, нэг ёсны «Шинэ толь хэмээх бичиг»-ийн дэвшилтэт үзэл санаа, шударга, эх оронч шүүмжлэлийг үргэлжлүүлэн гүнзгийрүүлсэн, илүү туршлагажсан, илүү далайцтай нийтлэлтэй залгамжлагч сонин байсан төдийгүй, ард түмний эрх ашгийг тууштай хамгаалж, Монголын феодалын байгууллын хоцрогдол, ихэс дээдэс, ноёд түшмэдийн бусармаг явдлыг хурц шүүмжилж, улс үндэстнийхээ тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, харийн түрэмгийллийн эсрэг тууштай тэмцэх чиглэлийг баттай барьсан эх оронч, ардчилсан хэвлэл байв.

Хувьсгалын анхны жилүүдэд гарч байсан «Хураангуй сэтгүүл», «Нийслэлийн шинэ сонин», «Ардын эрх», «Ардын үндэсний эрх» сонин ч мөн адил «Шүүмжлэл» гэсэн тогтмол булан хөтөлж, төрийн яамдын түшмэд ажлын сахилга алдах, гаалийн ажилтан, хязгаарын сайд нарын дотор танил тал харах, хээл хахууль авах, ёс суртахуунаар доройтох, хууль завхруулах, хүрээний цагдаа нар хариуцлагагүй авирлах, албаны ажилд алагчлан бялдуучлах явдал үзэгдсээр байгааг элэглэн шүүмжилж байжээ.

Манай шинэ үеийн утга зохиолын чухал төрөл, зүйл болох шог, хошин зохиол, нийтлэлийг үндэслэгчийн нэгэнд Д. Нацагдоржийг зүй ёсоор оруулдаг³. Учир нь Д. Нацагдорж хуучин үеийн шог, хошин зохиол, тэрчлэн Орос-Зөвлөлтийн шог зохиолчдын бүтээлээс суралцаж, түүнээс үлгэр авч, манай нийгмийн дэвшил, хүмүүсийн

өдөр тутмын амьдрал ахуй, үйл ажиллагаанд саад тогтор учруулсан элдэв дутагдал, үеэ өнгөрөөж буй хорт үзэгдэл, мөхөж буй үзэл санаа, бүдүүлэг дадал заншлыг элэглэн дооглож байсныг түүний олон зохиол, бүтээл харуулж байна. Д. Нацагдоржийн бүтээлийг судлаач С. Лувсанвандан «Харгис хуучныг илчлэн ташуурдах ялалтын шог шүүмжлэл бөгөөд ардын хувьсгалын үр дүн болсон шинэ бодит байдлын уран сайхны нээлт юм»⁴ гэж үнэлжээ.

Д. Нацагдорж сэтгүүлчийн гараагаа 1924 онд «Ардын цэрэг» сонины эрхлэгч болсноор эхэлжээ. Тэрээр жил гаруй хугацаанд тус сонины 27 дугаарыг эрхлэн гаргасан бөгөөд сонины хэл найруулгыг сайжруулсны дээр утга агуулгыг нь улам гүнзгийрүүлжээ. 1930-1931 онд Д. Нацагдорж «Залуучуудын үнэн» сонинд утга зохиолын ажилтан, сурвалжлагчаар ажиллаж байв. Тэрээр сонинд материал бичээд зогсоогүй, сонины үзэмж зохиомжийг сайжруулахад санаачилгатай ажиллаж байжээ. Түүний нийтлэлүүдэд гэгээрүүлэгч, хүмүүжүүлэгч үзэл нэвт шингэсэн байдгаараа онцлогтой. Д. Нацагдорж «Ардын цэрэг», «Залуучуудын үнэн», «Залгамжлагч», «Хувьсгалын уран зохиол», «Шинжлэх ухаан» зэрэг хэд хэдэн сонин, сэтгүүлийг бий болгох, мөн Германд «Сурагчдын сэтгүүл» гаргахад манлайлж идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн юм.

Хувьсгалын эхний жилүүдийн нэрт сэтгүүлч Г. Навааннамжил тодорхой нэр, хаяг заан хурц дайчин шүүмжлэл бичиж байсан нь их ач холбогдолтой юм. Түүний санаачилсан «Бядан явагч бялзуухай миний өгүүлэл» шог, хошин нийтлэлийн булан манай хэвлэлүүдэд нийтлэлийн уламжлалт хэлбэр болсон бөгөөд саяхан болтол сонины

хуудаснаа оршсоор байв⁵. Энэхүү буланд манай ахмад зохиолч, сэтгүүлч Д. Нацагдорж, С. Буяннэмэх, Г. Навааннамжил, Ц. Дамдинсүрэн, Ц. Цэдэнжав, Д. Цэвэгмэд нар тогтмол бичиж байв.

Гучаад оны «Үнэн» сонинд «Бядан явагч бялзуухай миний өгүүлэл», «Залуучуудын үнэн» сонинд «Тойрон нисч тодорхой танилцуулагч тогтмол миний өгүүлэл» гэх мэт тогтмол булан гарч байв. Эдгээр буланд бялзуухай, тогтмол шувуу үзсэн харснаа өгүүлж байгаа байдлаар шог, хошин, ёгт өгүүллэг, найруулал нийтэлж байжээ. Энэ хоёр булан тухайн үедээ уншигч олны анхаарлыг татаж, феодалын нийгмийн үлдэгдэл, шашны номлолын хор уршиг, ажлын дутагдал хоцрогдлыг шог хурц үгээр төөнөн эмчлэх хэрэгслийн нэг болж байв. Тавиад оны эцсээс «Утга зохиол, урлаг» сонины газар «Бядан явагч бялзуухай миний өгүүлэл» буланг сэргээж, 1980-аад он хүртэл хөтөлж иржээ.

1934 онд МАХН-ын IX их хурлаас феодалын нийгмийн үлдэгдэлтэй хийх тэмцлийг эрчимжүүлэхийг чиг үүрэг болгосон байна. Тус их хурлаас дэвшүүлсэн асуудлын хүрээнд МХЗЭ-ийн Төв Хорооноос залуу үеийг өнгөрсөн нийгмийн сэтгэлгээ, хоцрогдол, нөлөөнөөс ангижруулах, тэднийг ажилч хичээнгүй, соёлч, эвсэг, нөхөрсөг болгож хүмүүжүүлэх зорилтыг тавьсан байна. Зохио бэлтгэлийг хангасны үндсэн дээр МХЗЭ-ийн Төв Хорооны хэвлэл «Хүмүүжил ба жигшил» сэтгүүлийн анхны дугаар 1935 оны 11-р сарын дундуур 3000 хувь хэвлэгдэн гарчээ. Манай шог, хошин тогтмол хэвлэлийн анхдагч нь болсон улс төр-уран сайхны энэхүү сэтгүүл болон түүнийг залгамжлагч хэвлэлүүд өнгөрөгч 70 гаруй жилийн турш манай нийгмийн хөгжилд саад тогтор бологч

хүнд суртал, залхуу хойрго байдал, амч хөрөнгө шамшигдуулагчид, хөдөлмөрөөс хойш суугчид, ёс суртахуунаар доголдогсод, луйварчид, хулгайч нар, архицидтай ширүүн тэмцэл хийсээр ирсэн билээ.

«Хүмүүжил ба жигшил» сэтгүүлийн анхны эрхлэгч нь Д. Содномдорж, хэвлэлийн эрхлэгч нь нэрт дипломатч Баярын Жаргалсайхан, зураач нь О. Санжжав байжээ. Эрхлэгч Д. Содномдорж анхны дугаарт бичихдээ: «Ардын залуучууд ба ард түмний дотор үлдэж хоцорсон бөгөөд шинэ соёл боловсролыг хөгжүүлэхэд саад хийж буй феодал ёсны үлдэгдлүүдийг хайр найргүй тэмцэж, тэдгээрийг могой үзсэн мэт жигшиж хүмүүжих явдал бол даруй феодал ёсны үлдэгдлийг устгаж, шинэ соёл боловсролыг хөгжүүлж чадах дор тустай амой» гэжээ.

Энэ дугаарт шог зураач О. Санжжавын зурсан, жадан дээрээ намирсан улаан туг хийсгэсэн урт буутай, монгол дээл, гуталтай эрэгтэй хүний ар хормойноос хар, шар хоёр феодал зүүгдсэн зураг нийтлэгдсэн байна. Улаан туг дээр нь «Феодал ёсны үлдэгдлийг тэмцэн устгаж үндэсний ба хувьсгалын соёл боловсролыг хөгжүүл» гэж бичжээ. Мөн Ц. Дамдинсүрэн, Ши. Аюуш, Д. Сэнгээ, Д. Нацагдорж, Дүгэржав, М. Чимэд нарын бичсэн шүлэг зохиол, шог, хошин өгүүллэг гарсан байна. «Хүмүүжил ба жигшил»-ийн сэтгүүлчид гол төлөв хуучин нийгмийн дутагдлыг шүүмжилж байсан бөгөөд «39 оны хэлмэгдүүлэлтийг хүртэл хэн ч хэлэх гэснээ

хэлдэг, бичдэг их чөлөөтэй үе байсан»-ыг хожим дурдсан нь бий⁶.

«Хурц дөл» сэтгүүлийг 1941 онд МХЗЭ-ийн Төв Хорооноос эрхлэн хоёр дугаар гаргажээ. Энэ сэтгүүлийн хариуцлагатай эрхлэгч нь Д. Суръяа, нийтлэгч гишүүд нь Д. Чойдог, Д. Цэрэндорж, Ло. Цэнд-Очир, Ю. Баатар нар байжээ. Сэтгүүлийн эхний дугаарт «Буруу санаа хортой», «Өвс хадах төлөв», «Хүнд суртал», «Сүүлгүй чоно», «Хайдав, Ойдов хоёр» гэх мэт шоглож шоолсон нийтлэлүүд хэвлэгдсэн байна.

«Хурц дөл»-ийн халааг авсан, 1942 оны 1-р сард анхны дугаар нь гарсан «Матар» сэтгүүл бол Монголын шог, хошин нийтлэлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан түүхэн тогтмол хэвлэл юм. Ер нь

энэ үеийн манай тогтмол хэвлэлүүдийн нийтлэл нь ерөнхийдөө илчлэн шүүмжилсэн шинжтэй боловч шог, хошин нийтлэлийн төрөл, зүйл багахан байлаа. Тэдгээр хэвлэлийн олонх нь «Шүүмжлэл» тогтмол булан хөтөлж, түүндээ цаг үеийн бурангуй үзэгдлийг шүүмжлэн шоглосон хурц дайчин нийтлэлийн буухиаг таслалгүй үргэлжлүүлж иржээ.

МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчид 1943 оны 7-р сарын 26-нд МХЗЭ-ийн Төв Хорооноос эрхлэн гаргаж байсан «Матар» сэтгүүлийг «Үнэн» сонины харьяанд шилжүүлж, зөвхөн эвлэлийн биш, нийт улс орны хэмжээний ажлын дутагдлыг шоглон шүүмжилж байхыг үүрэг болгосон байна. Сэтгүүлийн хариуцлагатай эрхлэгчээр эрдэмтэн зохиолч Ц. Дамдинсүрэнг,

хариуцлагатай нарийн бичгийн даргаар нь Д. Даржааг, гишүүдээр нь Чойдог, Пүрэв нарыг томилжээ.

«Матар» 1961 оны 1-р сараас 1965 оны 12-р сар хүртэл «Хүмүүжил жигшил» хэмээх хуучин нэрээрээ гарсан байна. Эдгээр нь сар тутмын хэвлэл байсан бөгөөд үндсэндээ өөр өөр нэрээр хэвлэгдэж байсан боловч нэг сэтгүүл байжээ. «Матар» сэтгүүл 1942-1945 онд монгол бичгээр, 1946 оноос хойш кирилл үсгээр гарах болжээ. «Матар» сэтгүүл нь гол төлөв Дэлхийн хоёрдугаар дайны үе, тухайлбал: Халх голын дайн, Зөвлөлтийн Эх орны аугаа их дайн, 1945 оны чөлөөлөх дайн, дайны дараах бүтээн байгуулалтын сэдвийг тусгаж байсан юм. Түүнчлэн дотоодод хэвлэгдсэн ном зохиолд үг үсгийн алдаа их гардаг тухай шог яриа шүүмжлэл олноор нийтлэгдэж байжээ. Жишээлэхэд номын дэлгүүрийн худалдагч ном авсан хүнд «Наад ном чинь үг үсгийн алдаа ихтэй шүү. Юуны төлөө та хоёр нүдтэй билээ. Номоо уншихдаа алдаагүй нь сайн хараад уншихдаг байх хэрэгтэй» гэж зөвлөхдөө хүрснийг шоглосон байдаг.

«Матар» сэтгүүлийн нийтлэлийн гол төрөл, зүйл нь шог найруулал, шог мэдээ, шог үзэгдэл, шог яриа, ёгт үлгэр байв. Үүний зэрэгцээ хошин зүйр үг, явган шог, хошин оньсого, шог дуу бас нийтлэгдэж байжээ. Шог, хошин нийтлэлийн гол төрөл, зүйл болох шог найруулал 1940-өөд оны сүүл 1950-иад оны эхэн үеэс «Матар» сэтгүүлд нийтлэгдэж эхэлсэн байдаг. Тус сэтгүүлийн эхний дугааруудад шог, хошин төрөлд хамаарахааргүй нийтлэл цөөнгүй байв. Харин 1943 оны сүүл, 1944 оны эхний дугааруудаас «Матар» сэтгүүлийн шог, хошин нийтлэл нилээд зүгширч

төлөвших хандлагатай болсон нь ажиглагддаг.

Сэтгүүлийн анхны дугааруудад Дагийн су юм уу, Да-гийн сурвалжлага, Го-гийн сурвалжлага, У-гийн су гэх мэт нэрийг эс тооцвол зохиогчийн нэрийг бараг тавьдаггүй байв. Гэхдээ цөөхөн тооны тогтмол бичигчид нь нэрээрээ бүтээлээ гаргадаг байлаа. Харин 1940-өөд оны сүүлчээс эхлэн зохиогч бүр нэрээ тавьдаг болж хэвшжээ. «Матар» сэтгүүлийн эхний дугааруудын бас нэг онцлог гэвэл ихэнх материал нь идэвхтэн бичигчдийн захидлаас бүтдэг байжээ.

Сэтгүүлийн шог, хошин нийтлэлийн бичлэгийн зохиомжийн нэг онцлог нь өгүүлэх гэж байгаа зүйлийнхээ тухай эхэлж дурдаад, дараагаар нь тодорхой баримт, нэр ус, аймаг, сум, харьяалалтай бичдэг байсан явдал юм.

Манай зохиолчид шог мэдээг хуульч Сандагийн бичлэгийн арга, Бадарчны шог ярианы хэлбэрийг ашиглан туурвиж байжээ. Хуульч Сандагийн шог үгс, Бадарчны шог яриа нь шар, хар феодал, харийн худалдаачдын атгаг муу санаа, харгис бурангуй шинжийг уудлан илрүүлэх зэвсэг болж байсан бол дайны үед манай зохиолчдын бичсэн шог мэдээ, шог яриа нь фашистуудын хүн төрхөө алдсан авир, яргачин шинжийг илрүүлэн ниргэх зэвсэг болж байжээ.

Бүрэлдэн тогтож буй шог, хошин нийтлэл алдаа дутагдлаас ангид байж чадсангүй. Бичлэгийн төрөл, зүйл ядмаг, зарим нийтлэлийн уран дүр, дүрслэл тааруу, гэнэн, нуршуу болж байжээ. Бичлэгийн хурц, дайчин төрөл шог найруулал бараг үзэгдэхгүй байлаа. Тиймээс МАХН-ын Төв Хорооноос 1947 оны 5 дугаар сард баталсан «Монголын утга зохиолын одоогийн байдал ба түүний цаашдын зорилтын

тухай» тогтоолд «Дутагдалтай тэмцэх хурц зэвсэг шүүмжлэл ба элэглэлийн зохиол одоогоос дөнгөж бий болж байна» гэж тэмдэглэж, тийм төрөл, зүйлийн чухлыг заажээ.

Энэхүү тогтоолын дагуу «Матар» сэтгүүлийн шог, хошин нийтлэлийн чанарыг сайжруулахаар Монголын сэтгүүлчид, зохиолчдоос шат дараатай олон арга хэмжээ авсан байна. Сонин, сэтгүүлийн нийтлэлийн төрөл, зүйлийг баяжуулж, агуулга, үр нөлөөг нь сайжруулахад манай сэтгүүлчид байнга анхаарч иржээ. МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1947 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн «Үнэн» сонины ажлын тухай» тогтоолд шог, хошин зохиол, найруулал, өгүүлэл, гэрэл зураг, нэг хэв загварын хуурай бичлэг голлож байгааг шүүмжилсэн бол МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1952 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолд сонин хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл цөөн, агуулга нь өнгөцхөн байгаа болон «Матар» сэтгүүлийг шаардлагын дагуу удирдахгүй байгааг шүүмжилсэн байдаг.

«Матар» сэтгүүлийн эхний жилүүдийн дугааруудад идэвхтэн бичигчдийн материал зонхилж байсан бол 1940-өөд оны дунд үеэс бүтээлээ тогтмол нийтлүүлдэг мэргэжлийн төвшний шог, хошин сэтгүүлчдийн эгнээ өргөжжээ. Тэднийг Л. Бадарч, Ц. Цэдэнжав, Ш. Жамбалсүрэн, Д. Даржаа, Ц. Дамдинсүрэн, Б. Ринчен, Л. Ванган, Х. Пэрлээ, Б. Бааст, Б. Авирмэд нар манлайлж байв. Эдгээрээс Л. Бадарч, Ц. Цэдэнжав, Ш. Жамбалсүрэн нарын бүтээл сэтгүүлийн сүүлийн жилүүдийн нийтлэлийн гол цөмийг бүрдүүлдэг.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчоо 1960 оны 8-р сарын 5-нд гаргасан «Тогтмол хэвлэлийн нэр төрөл, чиглэлд зарим өөрчлөлт

оруулах тухай» 242 тоот тогтоолдоо «Матар» сэтгүүлийг өмнөх «Хүмүүжил жигшил» нэрээр нь гаргаж, чанарыг сайжруулахыг үүрэг болгожээ. 1961-1965 оны хооронд «Үнэн» сонины газраас эрхлэн гаргаж байсан «Хүмүүжил жигшил» нь «Матар» сэтгүүлийн нэг адил сар тутмын хэвлэл байсан юм.

«Хүмүүжил жигшил» сэтгүүлийн шог, хошин нийтлэлийн гол төрөл, зүйл нь шог найруулал, шог мэдээ, ёгт үлгэр байв. Эдгээр бичлэгийн төрөл, зүйлээс хамгийн түгээмэл нь шог найруулал юм. Ер нь «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн 1964, 1965 оны дугааруудын нийт материалын бараг 50 хувийг шог найруулал дангаараа эзэлж байв. Ер нь 1960-аад оны «Хүмүүжил жигшил», 1970-аад оны эхэн үеийн «Тоншуул» сэтгүүлд шог найруулал бичлэгийн төрөл, зүйлийнхээ хувьд нэгэнт хэвшиж, бүрэн төлөвшсөн байна.

Тус сэтгүүлийн нийтлэл нь албан ажил цалгардуулагчид, хариуцлагагүй албан тушаалтан, залилан мэхлэгчид, завшигчид, луйварчид, хөдөлмөрөөс зугатагсад, баяр цэнгэл хөөгчид, залхуучууд, цэцэрхэгчид, нийгмийн хөгжлөөс хоцрогсод, хүнд сурталтнууд, гэр бүлийн хүчирхийлэгчид, хүн чанараа алдагсад зэрэг сэдвээр бичигдэж байв.

«Хүмүүжил жигшил»-ийн шог, хошин нийтлэлийн зохиогчид нь Д. Баянбилэг, Даг. Жамъяан, Н. Иштавхай, Б. Бааст, Н. Цэвэгмэд, Д. Гармаа, М. Гүрсэд, Л. Лодоншарав, Г. Жамъяандорж, Ч. Ойдов, Е. Мийяа нар байсан юм.

Монголын шог, хошин нийтлэлийн ачааг дангаараа 40-өөд жил буюу хамгийн удаан үүрсэн түүхэн хэвлэл бол «Тоншуул» сэтгүүл юм. 1965 оны сүүлээр МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос шог, хошин сэтгүүлийн чанарыг сайжруулахыг дахин

үүрэг болж, «Хүмүүжил жигшил» сэтгүүлийн нэрийг «Тоншуул» болж өөрчилжээ. Анхны дугаар нь 1966 оны 1 дүгээр сард уншигчдын гар дээр очсон «Тоншуул» 2007 оныг хүртэл энэ нэрээрээ хэвлэгджээ. Тус сэтгүүлийн нийтлэлийн бодлого, агуулгад нилээд ахиц өөрчлөлт гарч, сэтгүүлчдийн ур чадвар нь «Хүмүүжил жигшил»-тэй харьцуулбал мэдэгдэхүйц дээшилсэн нь ажиглагддаг. Туурвихийн чанар чансаанаас гадна гоо зүйн мэдрэмж, оюуны соёлд ихээхэн өөрчлөлт оржээ. Бичлэгийн төрөл, зүйлийн дотор шог найруулал голлох байр эзэлсэн хэвээр байв.

«Тоншуул» сэтгүүлийн нийтлэлийн чанарыг сайжруулах тухай МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1966 оны 3-р сарын 7-ны өдрийн 7 дугаар тогтоолд сэтгүүлийн агуулга тавигдаж байгаа шаардлагаас хоцорч, шүүмжлэлт материал хэт жижгэрсэн, аар саар зүйлээр хөөцөлдөж байгаа зэргийг буруушааж, дутагдлыг засах арга замыг зааж өгчээ. Шүүмжийн ул мөрөөр бүтээлч ажил өрнөж, богино хугацаанд «Тоншуул»-ын хамт олон сэтгүүлийнхээ өнгө төрх, агуулгыг өөрчилж чадсан байна.

«Тоншуул» сэтгүүлийн ерөнхий эрхлэгч, судлаач Г. Дэлэг далаад онд «Манай орон социализмын материал техникийн бааз байгуулах ажлыг бүх талаар эрчимжүүлсэн 60-70-аад оны «Тоншуул» сэтгүүл социалист өмчийг үргэгдүүлэх явдалтай ширүүн тэмцэж, улс олон нийтийн өмчийг бидний юм, манай юм гэж ойлгодоггүй, арвиан хэмнэхийн оронд ашиг завшаан эрэгчдийг шүүмжлэлийнхээ гол бай болгож байлаа»⁷ хэмээн онцолж байжээ.

«Тоншуул» сэтгүүл 1983 оны 1-р сарын 1-нээс эхэлж 20 хоног тутмын хэвлэл болж, жилд 18 дугаар гаргах

болжээ. 1980-аад онд тус сэтгүүлийн шог, хошин нийтлэл ерөнхийдөө тэр үеийн Монгол орны олон нийтийн оюун санааны хөгжил дэвшлийн зогсонги байдал, хий хоосон дүрэмдэж хуралдсан уур амьсгал, соёрхол хүндэтгэлийн хишигт бялуурагчид, хуулиар, улсын ажлаар далайлган сүрдүүлдэг, хатуу донгоддог, цалингийн хувиар торгодог, үүрэгддэг сэтгэлгээ, төлөвлөгөө бие-лүүлэхийн төлөөх утга учиргүй, амьдралаас тасархай тэмцэл, цаас төлөвлөгөө, журам заавар, хуралдаан зөвлөгөөнд дулдуйдаж хэвшсэн явдлыг шүүмжилж, хошигнон өгөөдөж, элэглэн наргисан байдаг.

Харин 1990 оноос манай шог, хошин нийтлэл нь бичлэгийн арга барил, тусгах сэдвийн хувьд цоо шинэ эринтэй золгосон юм. Манай сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл явцууран цөөрч, нэг хэсэг нь ижилсэж, өөр хоорондоо уусч, дундаж саарал холимог нийтлэлүүд бий болсон⁸ энэ үед «Тоншуул» сэтгүүлийн, ер нь шог, хошин нийтлэлийн хувьд бичлэгийн төрөл, зүйлээ хадгалж үлдсэн нь дэвшилттэй юм.

1990 оноос хойш Монголын шог, хошин сэтгүүл зүйн гол төлөөлөгч болсон «Тоншуул»-ын нийтлэл ардчилал, ил тод байдал, хүний эрх, эрх чөлөө, баяр цэнгэл, улс төр, гэр бүлийн хүчирхийлэл, архи тамхи, авлига, хээл хахууль, мөнгө, хулгай дээрэм, цэнгээний газрууд, хэл ярианы соёл, боловсрол, өрнө, дорны зурхай, зах зээлийн үеийн хүний мөс чанар, залхуу хойрго байдал, албан ажил цалгардуулагчид зэрэг сэдвээр бичигдэх болжээ.

«Тоншуул»-ын нийтлэлүүд шог найруулал, шог, хошин өгүүлэл, өгөөдөл, хошигнол, наргиан, ёгт үлгэр, элэглэл зэрэг төрөл, зүйлээр туурвигдаж байсны дээр «Нутаг нутгийн шог» буландаа

явган шог яриа, орон нутгийн «Бэлэн Сэнгээ»-нүүдийн уран цэцэн яриаг нийтэлж байв.

«Тоншуул» сэтгүүл бол 1966 оноос 2007 он хүртэл 40-өөд жил гарахдаа социализм байгуулахад саад бологчдыг ч хорон үгээр хатгаж, ардчиллын он жилүүдэд ч ам хамхин суулгүй уран хошин үгээр шоглож ирсэн арвин баялаг түүхтэй хэвлэл мөн. Улс төр-уран сайхны шог, хошин сэтгүүл «Тоншуул» нь «Инээд байгаа газар эрүүл нийгэм оршино» гэсэн уриатайгаар дутагдалтай оршин тогтносон бүхий л хугацаандаа тэмцсэн хэвлэл билээ.

Нийгмийн «эмч» болсон «Тоншуул» сэтгүүл бол манай шог, хошин нийтлэлийн амьд жишээ болсон хэвлэл мөн. «Матар», «Хүмүүжил жигшил», «Тоншуул» сэтгүүлүүд бол Монголын шог, хошин сэтгүүл зүйн түүхэнд баларшгүй ул мөр үлдээж, нийгмийн хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан тогтмол хэвлэлүүд юм.

Ишлэл

1. Галбаатар Д. 2008. Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио, х. 318.
2. Мөнхбаяр Б. 2011. Монголын уран зохиолын тайлбар толь. УБ., х. 200.
3. Дашзэвэг Х. 1965. Д. Нацагдоржийн шог, хошин зохиолын уран дүрслэл, хэлний зарим онцлогоос // Монгол судлал. УБ., х. 240.
4. Луесанвандан С. 1973. Шог, хошин зохиолын учир // Монголын орчин үеийн уран зохиолын онол түүхийн асуудалд. УБ., х. 405.
5. Навааннамжил Г. 1956. Өвгөн бичээчийн өгүүлэл. УБ., х. 277-278.
6. «Тоншуул» сэтгүүл, 2005, №05 (908).
7. Дэлэг Г. 1975. «Тоншуул» сэтгүүлийн дөчин жил // «Үнэн» сонин, №269.
8. Зулькафиль М. 2007. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ., х. 211-212; Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. III дэвтэр. УБ., х. 220.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Галбаатар Д. 2008. Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь. Токио.
2. Гундалай Ш. 1989. Шог, хошин зохиол (Л. Бадарчийн уран бүтээлийн жишээн дээр). УБ.
3. Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
4. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. Тэргүүн боть. УБ.
5. Луесанвандан С. 1973. Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн асуудалд. УБ.
6. Мөнхбаяр Б. 2011. Н.Даваадаш. «XX зууны монгол зохиолчид» цуврал. УБ.
7. Навааннамжил Г. 1956. Өвгөн бичээчийн өгүүлэл. УБ.
8. Норовсүрэн Л. 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I, II, III дэвтэр. УБ.
9. Норовсүрэн Л. 2004, 2005, 2007. Монголын нийтлэл. I, II, III дэвтэр. УБ.
10. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. УБ.
11. Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ.
12. Виленский М. Э. 1982. Как написать фельетон. М.

Summary

Mongolia has very rich tradition of humoristic and satirical journalism. With the publication of the first social-political satirical magazine «The Nurturing and Disgust» the era of Mongolian humoristic and satirical journalism was founded in November 1935. In the last more 70 years Mongolian humor and satire has been developing through the pages of humoristic and satirical magazines such as: «The Crocodile», «The Nurturing, Disgust», «The Woodpecker» and other magazines and newspapers. During the period there have been a number of changes in genre, content and forms of humor and satire works. Moreover, a number of new types of satire have been developed and the features of writing and styles have been diversifying and enriching continuously. In the last periods the humor and satire in Mongolian journalism have been covering more than 20 main topics and have been utilizing more than 10 genres of writing.